



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 01 өдөр Дугаар 55

Хэрлэн сум

LV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 55 дугаар хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 12:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 85,0 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Чойбалсан хотод үүссэн коронавируст халдварын нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

1.1.Чойбалсан хот болон сумдын гэрийн тусгаарлан ажиглалтад хяналт тавих ажилд дайчлан ажиллах албан хаагчийн хуваарийг гаргаж аймгийн Онцгой комиссын тогтоолоор батлуулах,

1.2.Багийн Засаг даргын ажлын алба нарын дунд гэрийн тусгаарлан ажиглалтыг үр дүнтэй зохион байгуулах тухай болзолт уралдааны санал танилцуулах,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа нарт:

1.3.Улаанбаатар хот болон голомтлон гарч буй бүс, орон нутгаас Дорнод аймагт ирж тусгаарлагдаж буй хүүхдэд хяналт тавих, Боловсрол, соёл урлагийн газраас дэмжин тусалж хамтарч ажиллах,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан-д:

1.4.Улаанбаатар хот болон голомтлон гарч буй бүс, орон нутгаас Дорнод аймагт ирэх хүүхдийг зөвхөн өөрийн төрсөн эцэг, эхийн хамт зорчуулах талаар олон нийтэд сурталчилж ажиллах,

[Signature] /М.Бадамсүрэн
[Signature] /Д.Баттулга

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

1.5.Дорнод аймагт ирэх хүүхдийг зөвхөн өөрийн төрсөн эцэг, эхийн хамт зорчуулах талаар олон нийтэд сурталчлах ажилд хяналт тавьж ажиллах,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан-д:

1.6.Улаанбаатар хот болон голомтлон гарч буй бүс, орон нутгаас Дорнод аймагт ирэх хүүхдийг зөвхөн өөрийн төрсөн эцэг, эхийн хамт зорчуулах талаар Улсын Онцгой комисст албан бичгээр хүсэлт хүргүүлэх,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:

1.7.Хэрлэн сумын иргэдийн гэрийн тусгаарлан ажиглалтад ашиглаж буй зөөврийн камерын хяналтыг нэмэгдүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.8.Дорнод аймгийг коронавируст халдварын улбар шар түвшинд шилжиж ажиллах бэлтгэл хангах,

1.9.Улаанбаатар хот болон бусад аймаг руу Дорнод аймгаас гарах иргэд хүндэтгэн үзэх шалтгаантай 13А,Б, буяны ажил, үндсэн харьяандаа ирэх, ачаа тээвэр, зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны тээвэрлэлтээс бусад бүх хөдөлгөөнийг хязгаарлах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

1.10.Дорнод аймгийн хэмжээнд коронавируст халдвар /COVID-19/-ын нөхцөл байдлын талаар мэдээллийг бэлтгэж Улсын Онцгой комисст албан бичгээр хүргүүлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,



Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.11.Вакцины бүрэн тунд хамрагдаж 14 хоносон иргэдийг тусгаарлах эсэх талаар Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яамтай зөвшилцөж судлан аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.12.Хүн ам олноор цуглардаг төрийн байгууллага, томоохон худалдааны төв, зах болон эрсдэлтэй газар ажиллаж буй ажилтан, үйлчлүүлэгч иргэдээс түүврийн аргаар тандалтын шинжилгээг авах ажлыг зохион байгуулж аймгийн Онцгой комиссын даргад танилцуулах,

 /М.Бадамсүрэн
 /Д.Баттулга

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.13.Дорнод аймгийн хэмжээнд үүрэг гүйцэтгэж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс тодорхойгүй хугацаагаар сунгаж ажиллуулах,

1.14.Аймгийн нутаг дэвсгэр дотроо бүх сумаас аймгийн төв рүү, мөн аймгийн төвөөс сумд руу зорчих хүсэлтэй иргэд www.70584647.mn бүртгүүлэн аймаг, сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр зорчуулах,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:



1.15.Халдварын улаан бүс, шинжилгээний баг, тусгаарлан ажиглах байранд дайчлагдан үүрэг гүйцэтгэж ажиллаж буй албан хаагч нарт урамшуулал олгох талаар санал танилцуулах,

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга, Онцгой комиссын гишүүн Э.Батболд,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.16.Аймгийн Онцгой комиссын 2021 оны 55 дугаар хурлаас гарсан шийдвэрийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх,


Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

1.17.Улаанбаатар хотоос ирэх хүсэлтэй иргэдийг зохион байгуулалттайгаар 8 хоногт 1 удаа автобусаар болон хувийн унаагаар нь зохион байгуулалттайгаар хүлээн авч, зориулалтын тусгаарлах байранд 7 хоногийн хугацаанд тусгаарлан ажиглаж, 6 дахь хоногт давтан шинжилгээнд хамруулж хариу сөрөг гарвал гэрт нь үргэлжлүүлэн 7 хоног тусгаарлах ажлыг зохион байгуулах,

 /М.Бадамсүрэн
 /Д.Баттулга

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа-д:

1.18.Тусгаарлах байрны зориулалтаар өрөө, тасалгаа тус бүрийг ариун цэврийн өрөөтэй болгож засварлах боломжтой сургуулийн дотуур байрыг судалж аймгийн Онцгой комиссын даргад танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА

